



**“ОД БҮРТГЭЛ АУДИТ” ХХК**

# **ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

**АНД-ЭНЕРГИ**  
ХУВЬЦААТ КОМПАНИ

---

**2017 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болгосон  
Санхүүгийн тайлангийн аудит**

“АНД-ЭНЕРГИ” ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2017 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН

---

**АГУУЛГА**

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	2
БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	3
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН	4-7
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН	8
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	9
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	10
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	11-12
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	13-36

## “АНД–ЭНЕРГИ” ХК

### ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

---

Анд–Энерги ХК-ийн (цаашид Компани гэх) гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаа, ерөнхий нягтлан бодогч Ч.Мөнхсаруул бид энэхүү тайлангийн 8–36 дахь хуудсанд үзүүлсэн компанийн санхүүгийн тайлангууд нь 2017 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, өмч, мөнгөн гүйлгээг СТОУС-уудад нийцүүлэн, Сангийн яамнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Ц.ГҮРРАГЧАА

Ч.МӨНХСАРУУЛ

**“АНД-ЭНЕРГИ” ХК**

**БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Үүсгэн байгуулах шийдвэр

“Анд-Энерги” ХК нь 2011 оны 5 дугаар сард үүсгэн байгуулагчдын шийдвэрээр байгуулагдан, 2011 оны 5 дугаар сард Монгол улсын Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, 2011015075 дугаартай 84669 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан. Байгууллагын регистрийн дугаар 4385772.

Хувьцаа эзэмшигчид

МУ-ын иргэн Т.Барс, Ц.Гүррагчаа, Д.Мөнхбаяр, Г.Түвшин нар тус бүр 16.5%-ийг эзэмшдэг. Бусад 34%-ийг жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшдэг.

Байнгын хаяг:

Баян замын 3-6, Уртын гол баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, Монгол Улс, “Анд-Энерги” ХК-ийн байр

Аудиторууд

“Од бүртгэл Аудит” ХХК

Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчид



# ОД БҮРТГЭЛ-АУДИТ

БАТАЛГААЖУУЛАЛТ, АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### “АНД-ЭНЕРГИ” ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД

#### Санхүүгийн Тайлангийн Аудитын Тайлан

##### Дүгнэлт

Бид, “АНД-ЭНЕРГИ” ХК-ийн (цаашид Компани гэх) 2017 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2017 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулсан байна.

##### Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн *Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёсзүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёсзүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёсзүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

##### Аудитын Гол Асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн их ач холбогдолтой, нөлөө бүхий асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй.